АРХИНЫ ЭСРЭГ ТЭМЦЛИЙН АРГА ТАКТИК, ДЭЛХИЙН ТУРШЛАГА

/Харьцуулсан судалгаа/

Г.Чулуун, Д.Батдорж

УИХ –ын гишүүн Л.Эрдэнэчимэг .. нарын хууль санаачлагчид архи, согтууруулах ундааны хяналтыг сайжруулах зорилгоор Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн [зарим] өөрчлөлтийн төсөл боловсруулах чиглэлд ажиллаж байгаагаа дурдаад, гадаадын улс орны эрх зүйн холбогдох зохицуулалтын талаар лавлагаа тодруулга гаргуулж авахаар УИХ –ын Тамгын газарт хандсан юм. Захиалагчийн хүсэлтийн[122] дагуу УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээний хэлтсээс ажлын бичил баг[123] гаргаж доорхи мэдээллийг бэлтгэв.

Архидан согтуурахтай тэмцэх, архитай өөртэй нь тэмцэх, аль алинаас нь үүсэх эцсийн үр дагавартай тэмцэх .. үг-ухагдахуунууд, утга чанарын хувьд хоорондоо бүгд ижил төстэй, бас ялгамжтай юм. Эд бүгдийг бид энд “архины эсрэг тэмцэл” нэрийн дор багцлав. Ингэх нь ядаж, ярих бичихэд хүртэл амар; гэж үзсэн болно. Архийг зөвхөн архи гэхээр, түүний хамсаатнууд .. согтууруулах .. спиртийн төрлийн .. бусад элдэв идээ ундаа сугарч үлдчих гээд байдаг тул хууль тогтоомжид тэдгээрийг арга буюу тоочин нэрлэх шаардлагатай болдог. Бид асуудлыг том зургаар нь, мөн чанарын талаас авч үзсэн болно.

Архи бол хүн төрөлхтний хэзээ цагаасаа үүрч ирсэн, ар нуруунаасаа аваад шидчихэж чаддаггүй нэг их гайтай хүнд ачаа, ангижирч чаддаггүй асар том зовлон гамшиг юм. Архины эсрэг сэтгэлгээний үүсэл тавил эртний түүхэн улбаатай. Хүн төрөлхтөн архийг “нээж” хэрэглээд 100 зууныг элээжээ. Үүний 46-д нь согтуурлын үр дагаварыг .. архины борлуулалтыг хянах гэж тэмцэж, .. дөнгөж сүүлийн ганц 100 жилд нь, энэндээ, шинжлэх ухааны үндэслэл түшсэн эрх зүйн арга механизмыг ашиглаж, ашиглахыг эрмэлзэж иржээ.

Энэ их тэмцэлд дэлхийн орон гүрэн бүр өөр өөрийн хувь нэмрээ оруулсаар ирсэн ч өнөөдрийн байдлаар зорилгодоо хүрсэн нь тооны хувьд цөөнх хэвээр аж. Бид мэдээж, гадаадын сайн туршлагаас авах суралцахыг эрмэлзэнэ. Нийгмээ архинаас ангижруулах тал дээр хаанахын хэнийг үлгэр болгон дуурайх вэ, хэнээс чухам юу суралцах вэ гэдэг нь ч өөрөө мөн, асуудал юм байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага олон жилийн өмнө архи алкоголийг, түүний хэрэглээний тархац, хор хөнөөлийн жин банг тооцсоны үндсэн дээр аюулын зэргээр нь эрэмбэлж №1 мансууруулагч дайснаар, героиныг №2-оор .. тамхийг №6 дайснаар тус тус зарлаж, улс орнуудын засгийн газарт архины эсрэг тэмцлийг, чухамхүү, наркотикийн эсрэг тэмцэлтэй адил хэмжээнд авч үзэхийг уриалж байсан түүхтэй юм.

Эл бяцхан бичвэрийн гол зорилго архины хор хөнөөл, түүний хэрэглээний үр дагаварыг тодруулах, эсхүл, өнөөгийн “манай нөхцөл байдлыг” дахин шинжлэхэд чиглээгүй юм. Эхнийхийг нь өнөөгийн шинжлэх ухаан олон салбар ухаанаар хангалттай нээж тогтоочихсон, “төгс шийдчихсэн” асуудал байдаг. Монголын нийгмийн “архины орчин нөхцлийн талаар” холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд үндэслэл тооцоо бүхий мэдээ тайлан .. олныг гаргажээ. Бид энд, асуудлыг “түүхэн туршлага”, “гадаадын туршлага” талаас нь харахыг эрмэлзлээ.

[122]УИХ-ын гишүүн, УИХ-ын Эмэгтэй гишүүдийн бүлгийн дарга Л.Эрдэнчимэгийн 2013 оны 5/1905 албан бичигт дурдсанаар;
[123]УИХ-ын Тамгын газрын ажилтан, шинжээч Д.Батдорж, Г.Чулуун;

Монгол дахь архидалтын хэмжээ нийгмийн үзэгдлийнхээ хувьд оргил цэгтээ хүрснийг бид бүгд харж ойлгож мэдэж мэдэрч байдаг. Үүнийг нэгэнт хийгдсэн олон судалгаа хангалттай баталдаг юм. Хууль санаачлагчдын зүгээс энэ байдлыг өөрчлөх журамлах үүднээс зарим санал санаачилга гаргасаар иржээ. Нэр бүхий хууль санаачлагчдын “хэрэгжээгүй нэг төсөл” (2012), нөхцөл байдлын танилцуулга, хуулийн үзэл баримтлал (нийт 4 хууд. материал)-ыг ард нэмж хавсаргав.

* * *

1. Дэлхийн архины газрын зураг

Умард хөршөөсөө бид уухыг [хүртэл] сурсан түүхтэй. Орост эдүгэ, ялангуяа хууль эрхзүйн хүрээндээ архины эсрэг тэмцлийг үргэлж ярьж, байнга “хэрэгжүүлж” байдаг ч үр дүн муутай, тэндэхийн 1 хүнд ногдох спиртийн хэрэглээ рекорд өндөр түвшинд хэвээр байна. Манайд ч мөн үзүүлэлт чамлахааргүй төвшинд оччихсон. Тэгэхээр, ижил зовлонтойгоо ижил зуршилтайгаа бодвол бид тийшээ (хойшоо) хармаар .. архины эсрэг зорилтот программ нь үр дүнгүй байгааг нь бодохлээр зэрэг .. өөр тийшээгээ өөр газарлуу хармаар хандмаар [болоод] байдаг. Ер нь, эхлээд эх дэлхийнхээ энгэр хавтгайг .. “хөлгөөн” нэг дүүрэн сайн харах хэрэгтэй юм байна. Тиймээс, “дэлхийн архины газрын зураг”-ийг, масштаб томтойгоос нь эхэлж сөхье[124].

Дээрх зурагт өөрөө график юм. Графикт, дэлхийн бөмбөрцгийг саарал ба ногоон 2 хэсэгт хуваажээ. Ногоон хэсэг нь спиртийн хэрэглээ багатай [архи уудаггүй] газар орны нутаг. Үггүй .. тоогүй энэ зураг дэлхийн архины тархац хэрэглээний талаар ихийг хэлдэг. Ногоон хэсгийн улс орны тоо, тэдгээрт хамаарах газар нутгийн хэмжээ үлдсэн нөгөө хэсгээсээ, энд хэдийгээр бага харагдаж байгаа ч, энд, манай гарагийн хамгийн олон хүн амтай “айл”, хятад энэтхэг .. багтаж байна. Хүний тоон талаас нь харвал, дэлхийн хүн зоны дийлэнх хэсэг буюу $^{2}/_{3}$ -нь, өнөөдөр, архи согтууруулах ундааг хир хэмжээнээс нь хэтрүүлэлгүй “тааруулан” хэрэглэж, ө. х. тэнд тухайн улс .. нийгмийнхээ архины хэрэглээг хянаж чадаж байна. Тэмдэглэхгүй орхиж ёсгүй харамсалтай зүйл бол, монголчууд бид дэлхийн архины газрын зургийн “энэ сайн хэсэг” -т харъяалагдаж хараахан амжаагүй явна.

[124]Янз бүрийн арга хэмжүүрээр гаргаж, өнгө ялгаж будсан иймэрхүү карт олон байв.

Сэдэвчилсэн энэ газрын зургаас харахад, картын ногоон хэсгийг архины “хатуу зохицуулалт” -тай улс орнууд дүүргэснийг доорх жагсаалтаас харна уу. Үүнд:

1. Албани
2. Алжир
3. Бангладеш
4. Бахрейн
5. Бенин
6. Бруней
7. Буркина-Фасо
8. Бурунди
9. Бутан
10. Зүүн Тимор
11. Гамби
12. Гана
13. Гвинея
14. Гвинея-Бисау
15. Джибути
16. Египет
17. Замби
18. Баруун Сахара
19. Зимбабве
20. Энэтхэг
21. Индонез
22. Иордани
23. Ирак
24. Иран
25. Йемен
26. Камбож
27. Камерун
28. Катар
29. Кени
30. Хятад
31. Коморын арлууд
32. Кот-д’Ивуар
33. Кувейт
34. Лаос
35. Лесото
36. Ливан
37. Ливи
38. Маврик
39. Мавритани
40. Мадагаскар
41. Малави
42. Малайз
43. Мали
44. Мальдив
45. Марокко
46. Мьянма
47. Непал
48. Нигер
49. Нигери
50. Норвеги
51. Арабын нэгдсэн эмирт улс
52. Оман
53. Пакистан
54. Палестин
55. Шинэ Папуа
56. Гвинея
57. Руанда
58. Саудын Араб
59. Свазиленд
60. Сейшелийн арлууд
61. Сенегал
62. Сингапур
63. Сирия
64. Сомали
65. Судан
66. Сьерра-Леоне
67. Тайланд
68. Танзани
69. Того
70. Тунис
71. Туркменистан
72. Турк
73. Уганда
74. Төв африкийн БНУ
75. Чад
76. Швед
77. Шри-Ланка
78. Экваторын Гвинея
79. Эритрея
80. Эфиопия

Эдүгэ дэлхийн нэр бүхий 41 улс [архины] хуурай хуультай, дахиад мөн төдий тооны улсад спиртийн төрлийн идээ ундааны “закон трезвости” (ухаалиг хэрэглээний дэглэм) үйлчилдэг. Дэлхий дээр, янз бүрийн том жижиг 416 шашин (урсгал) архигүй амьдралын номлолыг түгээж сурталдсаар ирсэн ба их бага 600 гаран үндэстэн уламжлалаараа архи хэрэглэлгүй явж ирсэн хэвээр байгаа аж. Гэтэл зарим газар байдал эсрэгээр, нэн таагүй байна. Орос, украйны нийгэм, жишээлбэл, архины гүн хордлоготой, бүх европ даяараа ерөнхийдөө “архины айсуй занал” –ын түгшүүр дор аж төрж байгаа дүр зурагтай юм.

Нийгэм дэх архины хэрэглээг хязгаарлаж зохицуулдаг 2 – 3 төрлийн хандлага төвшин байна; гэж үзэв. Үүний нэг нь, хаа сайгүй яригддаг “хуурай хууль”, нөгөөх нь саяын бидний дурдсан, ухаалиг хэрэглээг “албадсан шинж бүхий хатуу чанга зохицуулалт” юм. Эхнийхийг нь “сухой закон”, сүүлийнхийг нь зарим сурвалжид “закон трезвости” гэжээ. Ухаалиг хэрэглээг төрийн бодлогоор (харьцангуй зөөлөн) албадахдаа “с умом пусть пьют, а без ума .. то бьют” гэсэн үзэл хандлагаар явдаг гэх.

2. Архины эсрэг тэмцлийн [эртний] **түүхэн зарим ойллого**

Архийг хорих гэж, архины донг хязгаарлах гэж хүн төрөлхтөн үйлээ үзжээ. Энэ чиглэлд хийсэн түүхэн тэмцлийн эрч (ө. х. зохицуулагч талын атгалт-барьц цагийн уртад ерөнхийдөө суларч) саарч ирснийг доорхи тоймоос харж болно) Хууль дэгийн аргаар архины эсрэг тэмцэж байсан эртний жишээ элбэг байна. Тухайлбал,

- ХТӨ 2286 онд хятадад согтууруулах ундааг байнга хэтрүүлэн хэрэглэгч этгээдийг цаазаар авах тухай засаг эрхшээсэн хүний [зарласан] амлалт хөтөлбөр маягийн баримт байдаг гэдэг.

> Антиалкогольное законодательство в древнем мире. Примерно в 2286 г. до н. э. в Китае был издан эдикт (лат. edictum), предусматривающий суровое наказание (вплоть до смертной казни) за неумеренное и систематическое потребление опьяняющих напитков.

- Одоогийн (архигүй нийгэм) иракийн нутгаас олдсон, эртний Вавилоны эзэн Хаммурапи (ХЭӨ 1792 - 1750) –ийн зарлиг бол хүн төрөлхтөний түүхэнд бичмэлээрээ олдсон анхны хууль юм. Хаммурапийн хууль архины тухай заалттай. Тэнд, ".. эмэгтэй хүн согтуурч болохгүй, тэгсэн бол түүнийг харгис хатуу цээрлүүл" гэжээ. Тэр хаан эх хүнд эмэгтэй хүнд муу этгээд байсан учраас тэгээгүй, эрэгтэйчүүд тэртэй тэргүй уугаад дийлдэхгүй байсан учраас, ядаж "хүн төрөлхтөний мораль сайтай .. уудаггүй тал" –ыг хорноос хол байлгая гэж ийн шийдсэн байх.

  > Выдающимся памятником древневосточной правовой мысли являлись Законы Хаммурапи (1792 - 1750 г. до н. э.), увековеченные на черном базальтовом столбе. Одна из статей законов запрещала .. свободной женщине посещать корчму для питья сикеры. В случае нарушения запрета эту ".. женщину должны сжечь"

Эрхзүйн ямар ч түүхэн баримт бичгийн агуулга санааг өнөөгийн [хөгжлийн] өндөрлөгөөс харж шүүмжлэхдээ бид ихээхэн болгоомжтой хандах учиртай юм. Архины асуудал дээр "хэт хатуурхсан" байж мэдэх дээрх заалт тухайн үедээ үүргээн гүйцэтгэсэн байж таараа. Хаммурапийн хуульд актуаль чанараа өнөө хүртэл [ямар нэг хэмжээгээр] хадгалсан заалт олон байна. Архины биш жишээ авъя. 4000 жилийн өмнө буюу барилгын ямарч норм норматив байгаагүй (байх үндэсгүй) балар цагт тэр хаан "хэрэв барилга нурвал барилгачин өөрийн хөрөнгөөр сэргээн босгоно, хэрэв аваар гарч барилгын эзэн .. түүний гэр бүлийн хэн нэгэн осолдох ахул барилгачин болон түүний гэр бүлийнхний толгойг авна" гэж хуульчилжээ.

Хаммурапи хаан архины эсрэг тэмцээд зогсоогүй, спиртийн төрлийн бүтээгдэхүүний чанарын асуудалд ч анхаарч байв. Архин дарсны үйлдвэрлэгч нар "хэрэв, хэрэглэгчийг мэхлэн, ус холих замаар бүтээгдэхүүнээ ёс бусаар аривжуулбал, тэднийг [өөрсдийнх нь] чанаргүй дарстай торхонд нь үйж үхүүлэх.. " тухай зарлигдсан байдаг.

  > Во времена древневавилонского царя Хаммурапи владельцы питейных заведений, заподозренные в том, что разбавляют пиво водой, приговаривались к утоплению в бочке своего же фальсифицированного продукта.

- Эртний философчид архины асуудлыг олонтаа хөндсөн нь бий. Сократын шавь Антисфен (ХТӨ 444 - 366)-ний "Согтуурлын эсрэг" зохиол бий. Платоны "Хууль дүрэм, дэг ёс"зохиолд, залуу хойч үеийг архины гамшгаас сэрэмжлүүлэхийн чухлыг дурдаад, тэнд, "архи дарсыг 18 хүрээгүй бол амсч болохгүй", товчдоо (манайхны) 40 хүрээд дөнгөж эхэл; гэх маягийн гэсэн үзэл сургаал оржээ.

  > Лицам, достигшим возраста 30 лет, философ советовал ".. вкушать вино, но умеренно, ибо молодой человек должен совершенно воздерживаться от пьянства и обильного употребления вина. Достигшим сорока лет .. пировать на сисситиях[125] ".

Аристотель хэрэг явдлын бурууг архи руу чихэх ёсгүйг бичиж байж. Согтуу хүн өөрийгөө хянах чадвараа гээж улмаар хэрэг тарьдаг. "Мэдэхгүйгээсээн" болсон уу, "мэдэх чадвараан гээснээс" болсон уу гэдэг бол хоорондоо зарчмын ялгаатай зүйл мөн. Сүүлийн тохиолдолд нь согтуурагч этгээд "ухамсраан гээхийгээ .. ухамсартайгаар сонгосон" болж таарна; гэжээ.

[125] найр;

> Аристотель различал действия “по неведению” от действий “в неведении”. Так, пьяный совершает дурные поступки в неведении, то есть не осознавая, что делает. Но это сознательно избранная несознательность. Человек сознавал, чем и каким поведением может закончиться злоупотребление вином, какую ответственность он понесет в случае нарушения закона.

Хоёр эриний зааг үеийн эртний ромын төрийн зүтгэлтэн, философич Сенека архидалтын учир шалтгааныг үндэстний заншил уламжлалтай холбож үздэг байв. Зан заншил нь уламжлалыг уламжлах замаар өртөөлөн үргэлжилдэг, ингэж .. өмнөх үе хожим хойчийнхондоо (архидан найрлах) муу зуршилаа баталгаатай халдаана. Үүнд туслах мянга мянган дүрмийг дандаа “өмнөх үеийхэн” зохиожээ. Тэгдэг ингэдэг, тэгэх ёстой .. ингэх учиртай гэсэн хуучин дэг ёс архидалтыг нэг үеэс нөгөөд өвлүүлж байна. Үүндээ үг сургаал ашиглана. Энэ хорвоогийн хамгийн муу хүмүүс бол “хүний үгээр үг хийгч нар” юм. Сенека ингэж хэлсэн байна. Өгүүлснийг эш болговол монголын цагаан сар .. энэ тэрийг халах үндэслэл төвөггүй амархан олдохоор байна.

Афины хууль тогтоогч, эртний гэрэгийн гүн сэтгэгч Солон засаг захиргааны нэгжийн дарга удирдлагын хүрээнд архидалтыг нэгмөсөн шийдэх арга хэмжээ авч, “согтуурсан архонтыг цаазалж” байх хууль гаргажээ. Солон мөн, алкоголийн үйлчлэлийн хүчийг сулруулах, архи дарсанд тодорхой хэмжээний ус хольж найруулах тухай [жор] хууль гаргасан нь урт удаан хугацаанд мөрдөгдсөн гэдэг.

Архины градусыг 2020 хүртэл жилбүр системтэйгээр, 2 хэмээр бууруулах .. тухай санал санаачлага, хуулийн төсөл (мэдээ) ноднин (2012) жил дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр явж байсан. Төслийн агуулгын сайн мууг бид энд яриагүй. Асуудлын түүхэн давтамж нь сонин байгаа юм. Хүний нийгэм хичнээн ч их хөгжлөө гэсэн архийг хязгаарлах, архины эсрэг үйл ажиллагаан дээр очихоороо, нэг их холдоогүйн түүхэн жишээ энэ буюу.

Эртний гүн сэтгэгч, “домгийн” долоон мэргэний нэг Питтак ч эрхшээсэн газар орондоо архины хууль гаргаж байв. 10 орчим жил засаглаад улс орондоо дэг журам тогтоогоод .. эрх мэдлийн сэнтийнээс сайн дурааараа өөрөө буусан .. гэх хууль тогтоогч тэрбээр, “байгаагийн зоргоор ууж согтуурч болохгүй”, “хэн нэгний согтуудаа үйлдсэн гэмийн төлөө хүлээлгэх зэм эрүүл хүнийхээс 2 дахин хүнд байг” гэж хуульчилжээ. Энэ нь архины асуудалд хандах арга зарчмыг тодорхойлж өгч байгаагаараа нилээн онцлогтой, ихээхэн анхаарал татахаар үгс юм.

Чингэсийн Их засаг хуулийн XXIX зүйлд “Хүмүүс архи ууж согтвоос тэргүүнээ цохиулсан мэт аливаа оюун билиг хэрэггүй болмой” гэж заасан. Нийгмийн амьдралын дээд зарчмуудыг тогтоосон конституцийн шинжтэй, ориг эхээрээ олдсон, нууц товчоотой энэ тэнцэх энэ гайхамшигт цомхон баримт бичигт архины асуудлыг (хүртэл) тусгасан байгаа нь сонин юм.

Монголчуудын архины “зовлон” тэр үед ч байсан байх нь. Их л ууж байжээ дээ янз нь. Гэхдээ Их засгийн ихэнх заалт “гэмт этгээдийн эсрэг хандсан” маш хатуу чанга буюу ална мухируулна, өмчийг нь хураана, эхнэрийг нь шилжүүлнэ, жанчина ташуурдана.. гэхчилэнгийн заалттай байдаг бол, харин архины асуудал дээр [болохоор] харин, ерөнхийдөө “уухыг зөвшөөрсөн” гэхүйцээр зөөлөн хандсан байгаа юм. Дашрамд дурдахад Их засаг хуульд “мориныхоо толгой руу цохисон хүнийг ална” гэсэн байдаг.

“Их засгийн” XXIX заалт “архийг бүү амс, битгий уу” .. гээгүй, бүр “уувал ташуурдана .. цээрлүүлнэ” ч гээгүй, зүгээр л “архи гэдэг идээ аюултай эд ээ” гэж анхааруулах төдийхнөөр тунхаглаад өнгөрчээ. Манжийн үед согтуурагч этгээдийг эсгийд боодог байсан гэдэг.

Товчдоо, архины асуудалыг хүлцэн тэвчиж ирсэн монгол уламжлалын тухай ярьж болмоор байгаа юм. Энэ бүхэн “монгол нэрмэлийн цохилтын хүч сул” хөнөөл багатай байсантай холбоотой болов уу.

- Монголчууд эрт үеэсээ “унах морьгүй, тохох эмээлгүй бол хүн биш, дуу хуургүй бол .. найрыг найр биш” хэмээсээр ирсэн “найрлах дуртай” ард түмэн юм. Монгол найрыг архигүй, дуу хуургүйгээр төсөөлөхийн аргагүй. Домог түүхэндээ ч ийм. Жишээ нь, Аргусан хуурчийн домогт “Хулан хатныг авч ирэхэд .. Аргусан хуурч **арзанд согтож** [алтан хуурыг өөрөө “авч хонон”] буруутдаг. Ингэв гэж Богд бээр хилэгнэн “дуугүй тохь, өчиггүй тэвч” хэмээн Боорчи, Мухулай хоёрыг илгээнэ. Энэ нь өчиггүй алахыг тушаасан хэрэг байв. Гэвч Аргусан хуурч [ирсэн] хоёрт “алах хүний аялгууг авам гэлээ, үхэх хүн үгээ хэлнэ гэлээ” гээд хаан эзний хаалганы дэргэд очоод шүлэглэн хуурдав. Тэгсэн, их эзэн уяраад “хушууныхаа сайнд үлдэв чи, амныхаа сайнд аврагдав чи” гээд өршөөн хэлтрүүлнэ. Энд, буруутан этгээдийг архи уусан гэж шийтгэх гээгүй .. харин, архины халуунаар “юм авч хонолоо” гэж алахыг завдсан байгаа юм. Тэд архи ууж байжээ.

- Монголын нууц товчоо (§281) -нд, Өгөөдэй хаан үлгэргүй муухай загнаж архинд орсон тухай өгүүлдэг. Тэрбээр хаан ор сууж хамгийг захирах болсоор .. 4 муу үйл хийсэндээ гэмшин “.. олон иргэнийг дагуулах их үүргийг хүлээсэн байтал бор дарсанд шунасан минь нэгдүгээр буруу болов” хэмээжээ. Үүнийг манайхан өөрийн шүүмжлэл өрнүүлсэн .. гэх мэтээр магтан мандуулах нь элбэг. Ямар ч даргыг, хаааныг .. тэр тусмаа хожмын хүмүүс үзэн ядах ёсгүй. Гэхдээн “архинд орсон бол ямар ч сайн хүн байгаад нэмэргүй” –г бас хэлмээр байдаг. Тэд уугаад зогсохгүй .. зарим нь бүр архинд орж байжээ.

  Дашрамд тэмдэглэхэд, Орос гүрэн өнөөдөр архинд дийлдсэн төрхтэй байна. ОХУ -ын Ерөнхийлөгч Б. Ельцин (1931-2007) сүүлрүүгээ [ер нь бол] архинд сүрхий орсон, үүнийг дам нотлох олон жишээтэй. Гадаад монголын удирдагч маршал Х. Чойбалсанг зарим түүхчид “оросууд хойшоогоо түүнийг архины эмчилгээнд авч явсан” гэсэн бий.

  Хаад ноёд ууж цэнгэж байхад, харц ард ч доогууруа хир хэмжээндээ “найрлаж, түүгээрээ өөрийгөө болгож” байдаг. Дээрээ уугаад байгаа учраас дороо уугаад байдаг юм биш, харин, доогууруа хавтгайдаа “тулгаад” байгаа тэр зураг нийгмийн удирдлагын дээд түвшиндээ заавал илэрдэг байна. Тиймээс, алив нийгэм дэх архины эсрэг санаачлага хөдөлгөөн дээрээс эхтэй байх нь түгээмэл, жам ёсны бөгөөд сайн үйл байдаг; гэдэг. Тийн учраас хүн төрөлхтэн түүхэндээ хангалттай олон “хуурай хууль” –ийг энд тэндгүй дагаж мөрджээ. Хуурай хууль бүхэн их төлөв эхэлсэн шигээ мөн дуусвар болдог. Тэдгээрийг дандаа үр дүнгүй байсан гэж үзэх дүгнэх нь өрөөсгөл юм. Заримаас нь түүнийг тухайлж дурдъя.

3. Архины хуурай хууль

Хуурай хууль гэдэг нь согтууруулах үйлчилгээтэй этанол агуулсан спиртийн төрлийн бүтээгдэхүүний эргэлтийг бүрэн ба хэсэгчлэн хязгаарлах талаар гарсан засаг төрийн шийдвэр, үйлчлэл, хэрэгжилтийг хураангуйлж товчилсон (“урт нэртэй хууль” гэдэг шиг) яриан хэллэг юм. Хуурай хуулиар заримдаа хэсэгчилсэн хязгаарлатыг ч хийх эь бий учраас хуурай хууль болгон “хув хуурай” байдаггүйг хэлэх хэрэгтэй мэт.

Хуурай хуулийн орчинд эмнэлэг анагаахын, эсхүл, эрдэм шинжилгээний, үйлдвэр технологийн зориулалт бүхий спитртйин төрлийн бүтээгдэхүүнийг хязгаарладаггүй. Мөн, бүтээгдэхүүний этанолын агууламж нь хангалттай бага байх аваас түүнийг мөн “хуульд” хамааруулдаггүй байна.

а) **Хуурай хууль орост** ...

Дэлхийн нэгдүгээр дайны өмнөхөн, 1914.07.19 –нд орост, эзэн хааны зарлиг гарч, алкоголь агуулсан бүр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл худалдааг улс даяар хорьжээ. Энэхүү хуурай хуулийн хүрээнд,

- Өндөр хэмтэй архи дарсаар зөвхөн ресторанд орж үйлчлүүлж болдог байв. Архины хэрэглээний хязгаарлалтын ёс бусаар зөрчих оролдлого энд тэнд бишгүйдээ гарч байсан ч хуурай хуулийн хэрэгжилтийн дүнд 1 хүнд ногдох алкоголийн дундаж хэрэглээ өмнөх (1913) -өөсөө 10 дахин багассан үзүүлэлт [дорхноо] гарсан гэдэг. (Табл.)

Он жилүүд	1 хүнд ногдох хэмжээ (л.)	Тайлбар
1910	3.4	
1913	4.7	
		1914 онд цагаан хааны зарлигаар хуурай хууль нэвтрүүлсэн
1915	0.2	
1925	0.9	
1940	1.9	
1960	4.7	
1965	5.0	
1980	11.0	
		1985 онд [горбачевын] хуурай хууль гарсан
1986	4.0	
1996	16.0	
2001	18.0	

- Согтуугаар хэрэг төвөгт холбогдож баривчлагдсан хүний тоо, орост 1914 оны II хагаст, эхнийхээсээ 70% -аар огцом буурсан байв. Эрүүлжигдсэн хүний тоо 29 дахин цөөрчээ. Архидалттай дам холбоотой сэдлээр амиа хорлосон хүний тоо 2 дахин багасав. Энэ мэт харьцуулсан үзүүлэлтүүд өөр 9 гүбернийн хэмжээнд авагдсан ижил төстэй судалгаагаар давхар батлагджээ. Хуурай хуулийн дараах он жилүүлэл иргэдийн банкин дахь мөнгөн хадгаламжийн хэмжээ эрс (2. 7 дахин) өссөн; гэдэг.

Дээрх архины эсрэг кампани (арга хэмжээ) –ийн хэрэгжилтийн үр дүнгээр илтэд бахархсан тухайн үеийн улстөрч, төрийн Думын гишүүн, тариачин И. Евсеев .. нар хуурай хуулийг үеийн үед “үүрд мөрдөх” санал гаргаж байсны үндэслэлд,

- [Нийгмийн хэмжээнд] гэмт хэрэг буурлаа, гудамжны үймээн самуун намдлаа, өлсгөлөн гуйланчлал багаслаа, орон шорон хоосорлоо, айл гэрт амгалан тайван ирлээ, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж аж амьдралын төвшин дээшиллээ, орос орон айхавтар нэгэн гамшиг зовонгоосоо ангижирлаа .. хөл дээрээ бослоо. Архигүй нийгэм боломжгүй зүйл гэж гуаглаж эсэргүүцэж байсан тэр хүмүүс ичээсэй” гэх зэргээр өгүүлсэн байв.

1917 онд зөвлөлт засаг гарч ирээд хуурай хуулийг цааш үргэлжлүүлэн мөрдөхдөө зарим шийтгэлийг нь эрс чангатгасан юм. 1919 онд гарсан В. Лениний гарын үсэгтэй «О воспрещении на территории страны изготовления и продажи спирта, крепких напитков и не относящихся к напиткам спиртосодержащих веществ» - шийдвэрээр .. архи үйлдвэрлэж худалдсан этгээдийг 5 жилийн хорьж, хөрөнгийг нь хураа .. ”

гэжээ. Харин, 1923 оноос орост архи үйлвэрлэх худалдах явдлыг эргэж зөвшөөрсөн байдаг.

ЗХУ-ын үед архины эсрэг нийтдээ 5 удаагийн кампанит арга ажиллагаа өрнүүлсний сүүлийх нь 1985 – 1987 онд тохиожээ. Үүнд:

1918 - 1923
- Архи үйлдвэрлэх худалдахыг хориглов;

1929
- Пиво үйлдвэрлэлийг зогсоож, гоожуурын газрууд (баар мухлаг) -ыг хаав;

1958
- Согтууруулах ундааны борлуулалтын цэгийн тоог эрс цөөлөв;

1972
- Согтоох чадал ихтэй, өндөр хэмтэй архи конъякны үйлдвэрлэлийг багасгаж, оронд нь пиво дарсны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэв. Бодлогын хэрэгжилтийг хангах явцдаа, шийдвэр гарах үед худалдааны эргэлтэнд борлогдож амжаагүй байсан өндөр градустай архи, архин бүтээгдэхүүнийг агуулах лангуунаас шууд хураан (америкууд газар дээр нь устгадаг, харж байгаад устгуулдаг бол орост хурааж аваад ачаад явчихдаг бололтой) авчээ;

1985 - 1987
- ЗХУ-ын коммунист намын төв хорооны “архидалтыг арилгах .. ” [алдарт] тогтоол[126] гарч, нийгэм дэх архидалтын эсрэг зохион байгуулалтын цогц шинжтэй олон арга хэмжээ авсан байна. Тогтоолын хэрэгжилийн явц дахь “уусан этгээдийг шийтгэх” чиглэлийн санкцууд нь харин харьцангуй зөөлөн, их төлөв, захиргааны арга хэмжээ төдийхнөөр хязгаарлагдаж байсныг тэмдэглэх нь зөв болов уу.

  Төв хорооны тогтоолын дагуу (нэг талд нь) архины дэлгүүр тасгийн ажиллах цагийг багасгах, уух суух газрын тоог цөөлөх, ажлын байранд уусан этгээдэд ногдох шийтгэлийг чангатгаж байсан ба (нөгөө талд нь) архигүй хуримыг сурталчлах .. зэргээр үзэл суртлын чанартай явуур муутай арга ажиллагаа өрнүүлж байжээ.

  1985-987 онд хүчлэн хэрэгжүүлсэн архины хуурай хуулийн үр дагавар улс оны эдийн засагт эерэгээр биш эсрэгээр, сөргөөр нөлөөлсөн байна. Архин төрлийн бүтээгдэхүүний борлуулалт багассанаас болж хүнсний үйлвэрлэлийн салбараас улсын төсөвт төвлөрдөг байсан нийт орлогын хэмжээ 33% -аар буюу 38 тэрбум (1985 оны рубл.) болтлоо унаж .. санхүүгийн алдагдал, мөн олон нийтийн дургүйцэл энэ бүхэн горбачевын хуурай хуулийг “2 ойнд нь хүргээгүй” юм. Эндээс үзэхэд, ЗХУ –ын үеийн социалист төсөв өнөөгийн судлаачдын яриад байгаа шиг архи түшсэн “согтуу төсөв” байсан нь илт байна.

Байдал орост сүүлрүүгээ бүр хүндэрсэн. Энэ нь империйн задрал, эдийн засгийн хямралтай шууд холбоотой байв. 1990-ээд онд их оросын зарим муж улсад “архиар цалин тавьдаг” болж байсан удаатай. Архин цалингийн асуудал монголд ч мөн тэр үед давтагдсан билээ.

[126] Постановление ЦК КПСС «О мерах по преодолению пьянства и алкоголизма».

b) **Хуурай хууль америкт** ...

Архины хуурай хууль, XIX зууны үеийн эхэн үеийн "эрхины эсрэг тэмцэл" –ийн туршлагаараа америкчууд алдартай. Тэнд, "АНУ –ын Конституцийн 18 дахь засвар" (Eighteenth Amendment to the United States Constitution) –аараа 1919.07.01 –нд архины хуурай хуулийг улс даяар тунхагласан. Энэ бол, архи алкоголийн хор хөнөөл заримдаа бүр үндсэн хуулийн агуулгын хэмжээнд яригдахуйц том асуудал байж хүртэл болдогийг харуулсан содон жишээ юм.

Үндсэн хуулийн XVIII засвараар, архи алкоголийн төрлийн согтууруулах ундааг хэрэглэхийг [бол] хориогүй, харин тэдгээрийг үйлдвэрлэх тээвэрлэх худалдахыг хориглосон юм. Үндсэн хуулийн энэ заалтыг сүүлд (1933) "буцааж авч хаясан" байдаг. Ингэх үндслэл бүхий учир шалтгаан олон байжээ.

Америкийн архины хуурай хууль халагдан халагдталаа олон түмний дунд сайн нэр дуулаагүй юм. Хуурай хуулийн үр дагавар улс орны эдийн засагт нь сөргөөр нөлөөлж, нийгмийн эрэлт дээр тулгуурласан дамын наймаа цэцэглэж, энэ чиглэлээр ажилладаг (татвар мэдээж төлдөггүй), зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн тоо эрс өсчээ. Хуурай хууль, түүнд холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах (1924) –д, олон муж улсад "энэ арга хэмжээ нуран унасан" (биелэлтийн эзлэх хувь жин 5 – 15% -ийг давж гараагүй) байлаа.

Хожмын судлаачдын хийсэн нийтлэг дүгнэлтээр бол, америкчуудын "мөрдсөн" хуурай хууль нийгмийг (архины төрлийн) эмгэг гамшгаас нь салгаж чадаагүйгээр барахгүй, бүр эсрэг эффект өгч коррупцийн шинэ орчин бүрдүүлсэн; гэжээ. Гэвч, дурдсан нийтлэг дүгнэлт "үнэн биш" байх бололцоотойг (наад захын) зарим тоо баримт харуулах мэт. Жишээ нь, хуурай хуулийн хэрэгжилт үр дүн бусдаас олон дахин илүү .. сайн байсан муж улсууд олон юм.

> Оклахома, Канзас и Миссисипи оставались «сухими» ещё в 1948 г.
> Штат Миссисипи последним из всех снял ограничения в 1966 г.

c) **Хуурай хууль финляндад ...**

Одоогоос ~100 жилийн тэртээ 1919.6.01 –нээс финляндад архины хуурай хууль үйлчилж байсан. Хуурай хуулийн үйлчлэлийн хүрээнд нэн түрүүнд тэнд архины үйлдвэрлэл, импорт, худалдааг засгийн газар бүрэн хяналандаа авч, уг салбарт төрийн монопол тогтоожээ. 1919 оны архины тэр хуурай хууль нь этанолын агууламж 2% -с давсан согтууруулах төрлийн бүтээгдэхүүнд хамаатаж байв.

Хуурай хууль зарим талаар сөрөг үр дүн өгсөн гэгддэг. Юун түрүүнд мөнөөх л архины хууль бус үйлдвэрлэл дамлал хаа сайгүй хавтгайрсан хэлбэрт шилжжээ. Улс гүрэн дамнасан спиртийн наймаа хянаж цагдаж дийлэхгүй байв. Финийн булангаар дамжих хөлөг онгоц бүхэнд балт орчмын орнуудаас болон герман польшоос гаралтай "спиртэн торпепо" багц багцаараа зүүлттэй явна. Торпедийг усан дотуур троссоор чирэх ба аюул занал үүссэн тохиолдолд канатаа салгаад л болоо. Хувийн жин багатай хөвөмтгий шингэн алтаа "тээвэрлэлтийн" явцад усан дор далд байлгах үүднээс давстай хамт баглах ба канатнаас салж далайн ёроол руу одсон "үнэт өмч" хэсэг хугацааны дараа, давсаа уусч дуусмагц өөрөө хөвөөд гараад ирдэг байв. Газар координатаа сайн мэдэж байвал дурандаж байгаад буцаж ирээд авчихна.

Хуурай хуулиас болж финляндчууд дарс экспортлогч орнууд (франц, португал) -тайгаа хэл амаа ололцохгүй байх .. зэрэг гадаад харилцааны асуудлууд ч гарч байжээ. Хуурай хууль хэрэгжүүлээд 3 жил болоход улс оронд гарч байсан бүх хэрэг зөрчилд холбогдосодын 80% нь архины хорио цээрийн гох дэгээнд өртөгсөд болж хувирлаа. Ингээд, хуурай хуулийг эргэж харах шинэ асуудал нийгэмд аажмаар өөрөө аяндаа босч иржээ.

1931 оны шувтаргаар финляндын төр засаг “асуудлыг ард түмнээсээ асууж шийдэх хувилбар” -ыг сонгож архины референдумыг зохион байгуулсан юм. Архины хуурай хуулийг халах уу яахав гэдгэг дээр ард нийтийн санал асуулга явуулахад оролцсон 763000 сонгогчийн 70% нь “архины төлөө гараа өргөсөн” байв. Энэ асуулгад финляндын нийт сонгогчийн 44% хамрагдсан. Архины референдумын үр дүнд тулгуурлан хууль тогтоох байгууллагаас холбогдох шийдвэрийг зохих процедурын дагуу гаргаж баталгаажуулжээ. Хуурай хуулиа финляндчууд ийнхүү “авч хаясан” ч архины үйлдвэрлэл борлуулалтыг улсаас дагнан хариуцах төрийн монополь эрхийг [хэн ч тэгтлээ] эсэргүүцээгүй юм.

d) **Хуурай хууль исламын орнуудад ...**

Дэлхийн архины газрын зургийг “сайн .. ногоон өнгө” –нд ямар улс орнууд хамаардгийг бид харсан. Тэд бол исламын орнууд юм. Ислам шашин шүтэгчийг мусульман хэмээнэ. Манайхан лалын шашинтнууд гэх. Лал, лало .. гэдэг нь төвдийн “буруу номтон” гэсэн үг тул “исламын .. ” гэдгээр нь өгүүлэв. Коран сударт архийг тас хорьдог. Дагасан олноо архи уулгахгүй байлгаж чадаж байгаа номлол сургаалийг “буруу ном” гээд байх нь зөв үү; гэсэн асуул ч аяндаа гарч ирж байна.

Исламын шажинтай бүх орон архины эсрэг хуультай мэтээр төсөөлж болохгүй. Архины асуудал өөрөө нийгмийн хурц эмзэг асуудал болж “босч” ирээгүй, тэртэй тэргүй спиртийн хэрэглээ багатай газарт архины хуурай хуулийн талаар “чанга” ярих нь өөрөө утгагүй байдаг биз ээ. Хэдий тийм ч, Иран, Египет, Саудын Араб, Нэгдсэн эмирт улсууд газар орондоо архины хязгаарлалтын хатуу хууль тогтоомжтой аж.

Арабын нэгдсэн эмирт улсад архины эсрэг хууль зөрчсөн “нутгийн хүнийг”-ыг 40 бэрээ занчиж шийтгэх, харин өөр шашинтан тэгэх аваас түүнд өндөр хэмжээ (750 фунт стерлинг) -ний торгууль ногдуулах ба хүндрүүлж үзэх үндэстэй бол 2.5 жил хүртэл хорих ял оноох .. гэх мэт жишээ жишиг исламын ертөнцөд байдаг байна. Гэхдээ энэ бүхнийг нь хуурай хуулийн хэмжээнд дүйцүүлэн авч үзэх ярих нь зарим талаар оновчтой биш гэсэн.

Хуурай хуульгүйгээр “хуурай” байж чадаж байгаа араб дахины гол “нууц” нь хүн бүгд тэнд шашны ариун ёсоо сүслэн дагадагт оршино; гэж үзэв.

e) **Хуурай хууль бусад зарим газар оронд ...**

Исландад, 1912 онд архи спиртийн төрлийн бүтээгдэхүүний борлуулалтад хяналт, хориг хязгаар тогтоож хуурай хууль хэрэгжүүлсэн байна. Энэ хориг 10 гаран жил үйлчлээд 1923 онд тавигдсан. Зарим мэдээнд, исландад пивоны үйлдвэрлэл худалдаа 1989 он хүртэл хязгаарлалттай хэвээр байсан; гэжээ. (В исландии .. при этом пиво было под запретом до 1989 года) Исландчуудыг хуурай хуулиа цуцлахад хөрш испанийн зүгээс нь үзүүлсэн “дарамт” шийдвэрлэх нөлөө үзүүлжээ. Ингэх шаардлагынх цаана нь гадаад худалдааны асуудал байсан юм. Архи дарсаа экспортлохын тулд сөрөг арга хэмжээ болгож исландын загасыг худалдаж авахгүй гэж айлгасан байна.
Норвегийн архины хуурай хуулийг 1919 оноос мөрдөж 1926 татгалзжээ. Зарим сурвалжид дагаж мөрдсөн хугацааг арай өөрөөр (1916-1927) заасан нь бий. Хуурай хуулиас татгалзах байдалд арга буюу хүргэсэн гол шалтгаан нь мөнөөх л загас импортлох эдийн засгийн .. улс хоорондын асуудал том асуудал байжээ. Норвегт хуурай хууль дагаж мөрсөн он жилүүдэд архины хэрэглээ 6 илүү дахин буурсан стат. мэдээтэй.

Канадад ч ийм хууль байсан. Тэр үе (1917-1920 –ood оны сүүлч) -ийн канадын хуурай хуулийн онцлог нь улсынхаа зарим муж хэсэгт хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлсэнд оршино. 1920 –иод оны төгсгөл хүртэл тэнд 2.5% -с дээш агууламжтай спиртийн төрлийн архи ундааг үйлдвэрлэх, тээвэрлэх, худалдан борлуулах, хэрэглэхийг хориглож байсан байна.

Ийм шийдвэр гарахаас их өмнө тэнд дороос эхтэй архигүйчүүдийн хөдөлгөөн хүчээ авч, архины эсрэг хуурай хуулийн 100 жилийн хугацаатайгаар улс даяар мөрдөхийг засаг төрөөс шаардаж байсан ба тэрхүү санаачилгыг хууль тогтоох, шийдвэр гаргах дээд төвшинд дэмжихгүй цаargалсаар их удаасан юм. Ингэхдээ “архины хэрэглээний асуудлаа нутгийн захиргааны байгууллагууд түүгээрээ өөрснөө мэдэж зохицуулаг” гэх маягийн арга зарчмаар бас нэг хэсэг явсан, явуулсан байна. Тэгж тэгж явсаар .. бүх нийтийн санал асуулгаар хуурай хуулийн арга замруу оржээ. Тэгэхэд, канадын квебект хүн амын 80% нь “архины хуурай хуулийн эсрэг зогсson” юм. Канадын “туршлагаар” бол архины хуурай хууль амархан төрдөггүй эд ажээ.

Чехэд (хагас) хуурай хуулийг (түр) хугацаагаар мөрдөж хэрэгжүүлсэн нь саяханы (2012) явдал юм. Тэнд 2012.9.14 - 27 –ны өдрүүдэд алкоголийн хэмжээ нь 20% -с давсан сонтууруулах төрлийн ундааг борлуулахыг хориглосон юм. Ийм арга хэмжээ авах болсон шалтгаан нь хэрэглэгчдийн метанолд хордох учрал давтамж ихссэн хэрэг зөрчлөөс үүджээ .. г. м.

Дагестаны парламент Алкогольт бүтээгдэхүүний борлуулалын хугацааны нэмэлт хязгаарлалтын тухай хуулийн төслийг 2013 оны IV сард хэлэлцэж дэмжив. Хуулийн төсөл нь рамадан сарыг тэмдэглэх, төгсөгчдийн хонхны баяр зэрэг (хэд хэдэн) олныг хамарсан хүндэтгэл ёслолын арга хэмжээ тохиох үеэр архи дарс зарахгүй байхыг тусгасан их төлөв гүйцэтгэн захирамжлах хүрээнд хамаатах шинж бүхий шийдлүүдийг агуулсан байв.

4. Нэмэлт зарим санаа

I. Архидалттай тэмцэх явцдаа хүн төрөлтөний олж хуримтлуулсан туршлага (мировой опыт) сэлтээс үзэхэд, нийгмийн энэ гамшигт үзэгдлээс ангижрах оролдлого тэмцэл бүхэн цаанаа ариун гэгээн сэдэлтэй ч ихээхэн адармаатай, эрсдэлтэй, “ялах баталгаагүй” урт удаан хугацааны тэсвэр тэвчээр, хүсэл зориг шаардсан нүсэр “кампанит ажил” байсаар ирсэн юм. Гэхдээ, архины эсрэг бодлого тэмцлийг алсын хараатай, системтэй, удаан хугацаанд шийдэмгий явуулж чадсан улс үндэстэн “аврагддаг” нь бас тодорхой байна. Энэ чиглэлд, шведийн туршлага анхаарал татахуйц байв.

II. Нийгэм дэх архидалтын хор хөнөөл, түүнээс ангиржрах арга замыг хүн төрөлхтөн “гарсан цагаас нь эхлэн” байнга бодсоор зорьсоор ирсэн тул “архины асуудал” өөрөө хүний нийгмийн хамгийн их анхаарч судлагдсан, хамгийн ил сэдэв юм. Зөвхөн 1990 онд, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас архидалтыг арилгах, үр дагаварыг тодруулах, урьдчилан сэргийлэх арга механизмыг боловсруулах .. эрдэм шинжлэлийн чанартай 353 судалгаа “авсан” байх жишээтэй. Архидан согтуурахаас сэргийлэх чиглэлд хийгдсэн эрдэм шинжилгээний ажил, ном товхимол, бүтээл судалгаа тоймгүй их. Тэгсэн хирнээ архины “нийгмийн аюулыг тэглэх нэгдсэн жор” -ыг өнөө болтол олоогүй байна; гэмээр ажээ.
Архидан согтуурахын эсрэг улс бүхний өрнүүлсэн, өрнүүлэх бодлого тэмцэл хоорондоо ижилгүй, тийм байх ч үндэсгүй юм байна. Яагаад гэвэл архины асуудал өөрөө хамгийн их судлагдсан сэдвийн нэг мөртөө, хэтэрхий олон хариутай буюу “шийдгүй бодлогын нэг” юм.

Олон улсын хэмжээнд үйл ажиллагаа өрнүүлдэг Архины эсрэг дэлхийн академи (ТББ) хүртэл байгуулагдаж, улс түмний төр нийгмийн дэлхийн хэмжээний зүтгэлтэн, бизнесменүүд" түүнд хүчээ нэгтгэж байгаа нь гадна талаасаа гоё сайхан зүйл боловчиг, архины аюулын өмнө хүн төрөлхтөн ерөнхийдөө "аргаа барж" хүчин мөхөсдөж, учраа олохгүй хэвээр байгааг илтгэн харуулах мэт.

III. Архидан согтуурах үзэгдлийн эсрэг дан гагц хууль тогтоох аргаар буюу "хорих хязгаарлах замаар" тэмцэх нь хангалтгүй "дутуудсан арга хэмжээ" болдог гэж үздэг юм байна. Ухуулан сэнхрүүлэх, шашин номын үзэл тунхаглалтай хамжих, нийгмийн "сэдэвчилсэн боловсрол" –ыг дээшлүүлэх, эмчилгээний арга механизм хэрэглэх .. зэргээр нэгдсэн үйл ажиллагааг өөр бусад чиглэлээр цогцоор өрнүүлэх нь амжилтад хүрэх магадлалыг ихэсгэдэг гэнэ.

IV. Архины эсрэг үзлийг хүний мөн чанараас салангид авч үзэж, жишээ нь, үндэслэлгүйгээр үнийг нь хэт нэмэх [энэ тэр] нь нийгмийн ядуу хэсгийг улам ядууруулах аюултай, зөв биш алхам байж мэднэ. Хүн мөнгөнийхөө хэмжээнаас хамаарч уудаг байсансан бол өдийд нийгмийн эмзэг хэсгийнхний дунд архидалт үгүй байхсан. Гэтэл байдал тиймгүй байгаа.

Эрдэмтдийн гаргасан судалгаагаар, эмэгтэйчүүдийн ихэнх (90%) нь архи дарс уулгүйгээр эр хүнтэй физик хавьталд орох боломжгүй; гэж үздэг нь тогтоогджээ. Энд гэрбүлийн гадуурх интим харилцааг хэлж байгаа юм. Тэгэхээр, архи согтууруулах ундаа хүн гэдэг амьтны үндсэн инстинктийн илэрцийг ямар нэг байдлаар дэмждэг, тэр чанарааараа "эзнээс нь салгахад хэцүү" тийм хэрэгцээ байх нь.

Хуурай хууль болгон хүссэн хэмжээний үр дүн өгдөггүй, өгсөн ч хэсэг хугацааны дараа ёс юм шиг цуцлагддагийн цаад учиг язгуурыг дан ганц "архины хамаарлаар" тайлбарлаж болохгүй юм байна. Архины асуудал бол дан ганц архины асуудал биш юм байна.

V. Үндэстний заншлын уламжлалт ёс горим, түүний инерц нийгэм дэх архидалтыг хөхиүлэн дэмждэг нэг ёсны бэлэн "сургууль" болой. Тиймээс зарим сэтгэгчид [угтаан бол] архигүй хуримын тухай биш, харин [яаж ерөөсөө] хуримыг өөрийг нь өөрчлөх вэ гэж бодох ёстойг сануулсан байна. Шашны ном сударт хурим найр сайн зүйл биш гэсэн үг сургааль уг нь бэлээхэн байгаа юм. Бид дагахгүй л байгаа болохоос биш.

Үндэсний том баяр ёс хавтгайрсан шинжтэй өрнөдөг. Заншил ёсоор түүнд эртнээс сайтар бэлдэх учиртай. Бэлтгэл ажлын хүрээнд архийг айл бүхэн авдар авдараар нь авч нөөцөлнө. Нэгэнт авчихсан архийг ууж тааараа, хүн. Хэсэг хугацааны дараа нөгөө нөөц дууссан байдаг. Ингээд бодохоор зэрэг "архидалтыг хязгаарлая гэвэл уламжлалт ёс, зан зашилтай хайр найргүй тэмц, түүнийг журамла" гэсэн эртний сэтгэгчийг үгийг анзаарахгүй орхиж боломгүй байна. Заншил ёсыг [зөөлөн, аажмаар] халж журамлах нь нийгмийг архидалтаас ангижруулах үйлсэд дэм өгнө.

VI. Тухайн нэг тодорхой улс үндэстний архины асуудалд хэр зэрэг чанга сул хандаж байгааг хялбаршуулан тандах арга механизм заавал байх ёстой .. олдох боломжтой санагддаг. ОХУ –ын Засгийн газрын тэргүүн нь архины асуудалд улам хатуу чанд хандах тухай итгэл төгс илтгэж байхад, Төрийн дум талд нь "бага зэргийн промильтэй" хүнд машин жолоодохыг зөвшөөрөх .. хуулийн төсөл явж байгаа зэргээс .. газар газрын архины асуудлаархи арга хандлагыг үнэнээр нь мэдэх ярвигтай байна. Ер нь, жолоочийг "уучлах промиль" –ийн хэмжээ хаана ямар байгаа нь энэ тал дээр их зүйлийг шууд хэлнэ; гэх мэтээр асуудлыг хялбаршуулж болохоор санагддаг.

VII. Архины хуурай хуулийн эсрэг үзэлтнүүд зөвхөн муу үзүүлэлтүүдийг түүгээд нэтгэчихдэг байж магадгүй байдал ажиглагдсан. Монголд “хуурай хууль” нүүрлэх нь гэж айсан нийтлэлүүд саяхан сонин хэвлэлд бишгүй нэг гарав. Тэнд илэрхий [нэг] худал мэдээлэл цохиж явна лээ. ЗХУ төсвийнхөө гуравны нэгийг архинаас олдог байсан гэдэг нь худал тоо юм. Зөвхөн хүнсний салбарын хэмжээнд хамаарах үзүүлэлтийг нийт улсын хэмжээнд “дөвийлгөн” хэрэглэж болохгүй биз ээ.

Аливаа хуулийн биелэлт нь түүнийг хэрэгжүүлэгчдийн хүсэл зоригоос шууд хамааралтай. Америкийн үндсэн хуулийн XVIII засварыг буцааж өөрчилчихөөд байхад, тэндэхийн цөөнгүй зарим муж улс хуурай хуулиндаа дуртай хэвээрээ, түүнийг олон жил урьдын адил үргэлжлүүлэн дагаж мөрдсөөр байсан юм. Тиймээс, архины хуурай хуулийн талаар гарсан гаргасан судалгаа тоо баримт, түүний тайлбар сэлт субъектив хандлага ихтэй .. тул, архины хуулийн талаарх аливаа дүгнэлтэд яаран итгэх хэрэггүй юм.

* * *